

МАЯГТ ОУИТБС-2-Г НӨХӨХ ЗААВАР

Ашигт малтмалын хайгуул эрхэлдэг аж ахуйн нэгж тайланг гаргахдаа энэхүү зааврыг баримтлана.

Ашигт малтмалын хайгуул эрхэлдэг аж ахуйн нэгж тайланг маягтаар үнэн зөв гаргаж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор Ашигт малтмалын болон Цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад аудитаар баталгаажуулан, нийтэд мэдээлсэн тайланг ирүүлнэ. Ашигт малтмалын болон Цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 3 дугаар сарын 1-ний дотор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын албанд маягтаар ирүүлнэ. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын алба 3 дугаар сарын 15-ны дотор Үндэсний статистикийн хороонд цахим хэлбэрээр ирүүлнэ.

А. ХАЯГИЙН ХЭСЭГ

- Аж ахуйн нэгжийн хуулийн албан ёсны нэрийг бичиж, регистрийн дугаарыг тавина.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэрийг үнэн зөв нөхнө.

Б. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

1.1 Тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Тусгай зөвшөөрлийн мэдээллийг ашигт малтмалын хайгуул эрхэлдэг аж ахуйн нэгж бүтээгдэхүүний нэр төрөл бүрээр гаргах бөгөөд багана 1, 2, 3-ыг тусгай зөвшөөрлөөс авч нөхнө. Багана 4-д тухайн ашигт малтмалын ордын оршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг болон газрын нэрийг тодорхой бичнэ.

1.2 Туршилтын олборлолт, борлуулалт

Тайлант жилд хайгуулын тусгай зөвшөөрлийн дагуу туршилтын журмаар олборлосон болон борлуулсан бүтээгдэхүүнийг нэр төрлөөр зааж зохих мөрөнд бичнэ. Олборлолт, борлуултыг багана 1, 3-т биет хэмжээгээр, багана 2, 4 –д мөнгөн хэмжээгээр илэрхийлнэ.

2. Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг

Энэ хэсэгт зөвхөн улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашгийг маягтад бичсэн төрөл ангиар ялган нягтлан бодохын мөнгөн суурьтай үнэлгээгээр гаргана.

2.1.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар. Аж ахуйн нэгжийн жилийн төлсөн татварыг бичнэ. Энэ татварт дараахь орлогоос төлсөн татвар орно. Үүнд:

- Ногдол ашгийн орлого,
- Эрхийн шимтгэлийн орлого,
- Хүүгийн орлого,
- Эрх борлуулсны орлого,
- Гадаадын аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газар өөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлсэн ашиг,
- Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлого,
- Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн зээлийн хүүгийн болон батлан даалт гаргасны төлбөр,
- Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн эрхийн шимтгэлийн орлого, санхүүгийн түрээсийн хүүгийн орлого,
- Удирдлагын зардалд төлсөн төлбөр,
- Түрээсийн төлбөр,
- Биет болон биет бус хөрөнгө ашиглуулсны орлого,
- Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлого зэрэгт ногдуулсан татварыг оруулан тооцож бичнэ.

Орлогын албан татварыг бусад татварын илүү төлөлтөөр суутгал хийсэн бол татварын суутгалын тооцоог тусад нь хавсаргана.

2.1.2 Гаалийн албан татвар. Зөвхөн гаалийн татварыг дангаар нь оруулна. Гаалийн татвартай хамт нэмэгдсэн өртгийн албан татвар төлсөн бол түүнийг гаалийн албан татварт оруулахгүй тусад салгаж, 2.1.3- т хамруулна.

2.1.3-2.1.13-т заасны дагуу хэрэв татварын албанд төлсөн бол зохих мөр баганад тавина.

2.1.8 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар. Энд зөвхөн 2010 он хамруулна.

Хэрэв татварын байгууллагад татвар хоорондын суутган хийсэн бол түүний талаарх тайлбарыг тайланд заавал хавсаргана.

2.2 Төлбөр. Тухайн жилд улсын төсөвт төлсөн төлбөр бүрээр гаргана.

2.3 Яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс, хураамж. Холбогдох хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгжээс яам болон агентлагуудад тухайн жилд төлсөн үйлчилгээний хөлс, хураамжийг зохих мөрөнд бөглөнө. Үүнд:

2.3.1 Гаалийн үйлчилгээний хураамж. Энд экспорт, импортын гаалийн бүрдүүлэлт хийсэн үйлчилгээний хураамжийг хамруулна.

2.3.2 Яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн тэмдэгтийн хураамжид дараахь төлбөрийг бичнэ.

Үүнд:

- Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрлийн хураамж,
- Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн хураамж,
- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрлийн хураамж,
- Тусгай зөвшөөрөл шаардагдах үйлдвэрлэл, үйлчилгээний зөвшөөрлийн хураамж,
- Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн хураамж,
- Замын цагдаагийн газарт төлсөн үнэмлэхийн хураамж, үзлэгийн хураамж,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд төлсөн тэмдэгтийн хураамж,
- Улсын нийгмийн даатгалын ерөнхий газарт төлсөн лавлагаа гаргуулсан хураамж.

2.3.3 Яам, төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлсөнд дараахь төлбөрийг хамруулна. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл авах, шилжүүлэх, барьцаалах, сунгуулах, талбайг буцаан хүлээлгэн өгөх, хилийн маргааныг шийдвэрлэх, үрэгдүүлсэн тусгай зөвшөөрлийг нөхөн олгох зэрэгт өргөдлийг хянан үзэх үйл ажиллагааны үйлчилгээний хөлс,
- Холбогдох байгууллагад жин баталгаажуулалтын хөлс, хэмжилтийн хөлс,
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон гадаад иргэдийг олон удаа орох гарах визний хуудас, үйлчилгээний хөлс, оршин суух зөвшөөрөл, тодорхойлолтын үнэ, хөдөлмөр эрхлэлтийн урилга,
- Ашигт малтмалын газарт лицензийн үйлчилгээний төлбөр, бүртгэлийн төлбөр, тайлангийн үйлчилгээ, геологийн багц мэдээллийн хөлс, талбайн захиалгын захиргааны хөлс, лиценз худалдан авах үйлчилгээний хөлс, тайлан хянуулах хөлс,
- Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд тусгай зөвшөөрлийн хөлс,
- Усны хэмнэлтийн төвд төлсөн үйлчилгээний хөлс,
- Сорьцын албанд сорьцын шинжилгээний зардал
- Стандарт хэмжил зүйн төвд нарийн хэмжүүрийн хөлс, стандартын үйлчилгээний хөлс,
- Татварын албанд зөвшөөрлийн хөлс зэрэг болно.

2.3.4-д Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний төлсөн үйлчилгээний хураамжийг бичнэ.

2.4 Төрийн өмчийн ногдол ашиг. Төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмчийн аж ахуйн нэгжийн тухайн жилд төлсөн ногдол ашиг багтана. Энэ хэсэг нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоогүй, төрийн байгууллагатай ногдол ашиг өгөх гэрээ хийгээгүй аж ахуйн нэгжид хамаарахгүй.

2.5 Бусад. Маягтын 2.5.1-д төлсөн бүх төрлийн торгуулийн дүнг бичнэ.

3. Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг. Энэ хэсэгт зөвхөн орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашгийг зохих нэр, ангиллын дагуу нөхнө. Хэрвээ орон нутгийн татварын байгууллагад татвар хоорондын суутган хийсэн бол түүний талаарх тайлбарыг тайланд заавал хавсаргана.

3.2 Төлбөр. Тухайн жилд орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийг маягтад заасан нэр төрлөөр ангилан нөхнө.

3.3 Нутгийн захиргааны байгууллагад төлсөн хураамж, үйлчилгээний хөлс. Холбогдох хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгжээс нутгийн захиргааны байгууллагад тухайн жилд төлсөн хураамж, үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсөвт төлсөн тэмдэгтийн хураамж, нутгийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс гэж салган зохих мөрөнд нөхнө.

3.4 Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг. Орон нутгийн төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмчит аж ахуйн нэгжээс тухайн жилд орон нутагт төлсөн ногдол ашгийг оруулна. Энэ хэсэг нь орон нутгийн өмчийн оролцоогүй, төрийн байгууллагатай ногдол ашиг өгөх гэрээ хийгээгүй аж ахуйн нэгжид хамаарахгүй.

3.5 Бусад. Энэ мөрөнд орон нутгийн төсөвт төлсөн бүх төрлийн торгуулийн дүнг бичнэ.

4. Бусад төлбөр ба зардал

4.1. Байгаль хамгаалах хамгаалах зардлын 50 хувь. "Ашигт малтмалын тухай" Монгол Улсын хуулийн 39.1.9-д заасны дагуу байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан дүнг бичнэ.

4.2. Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг. Аж ахуйн нэгж, байгууллагаас яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, бусад байгууллагад янз бүрийн зорилгоор өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив, дэмжлэгийг хэлнэ. Биет хэлбэр (мөнгөн бус)-ээр өгсөн хандив, дэмжлэгийг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр үнэлнэ. Яам, агентлагт өгсөн дэмжлэгт зөвхөн эдгээр байгууллагын төв аппаратад, аймаг, нийслэл, сум, дүүргийн тамгын газарт өгсөн хандив, дэмжлэгийг оруулна.

Тайлангийн энэ үзүүлэлтийг хандив, дэмжлэгийг өгсөн, хандив, дэмжлэгийг авсан аль аль тал нь гаргана. Хандив, дэмжлэгийг өгсөн огноо, хандив, дэмжлэгийг агуулга, үнийн дүнг жагсаалтаар гарган, энэхүү тайланд хавсаргана. Хэрвээ биет материалын хандив, дэмжлэг, эсхүл үйлчилгээ үзүүлсэн бол түүний нэрийг бичиж хавсралтад мөнгөн дүнд шилжүүлэн бичнэ.

В. САЙН ДУРЫН МЭДЭЭЛЭЛ

1. Тухайн аж ахуйн нэгж тусгай гэрээ, тодорхой нөхцлөөр хөнгөлүүлсэн, чөлөөлсөн татвар
2. Хөрөнгө оруулалтын зардал
3. Ажиллагчдын сургалт, хөгжилд зарцуулсан зардал
4. Геологи, хайгуулын зардал
5. Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал
6. Төрийн бус байгууллагад өгсөн мөнгөн хандив, дэмжлэг
7. Төрийн бус байгууллагад өгсөн мөнгөн бус хандив, дэмжлэг
8. Бусад аж ахуйн нэгж, байгууллагад өгсөн мөнгөн хандив, дэмжлэг
9. Бусад аж ахуйн нэгж, байгууллагад өгсөн мөнгөн бус хандив, дэмжлэг
10. Иргэдэд өгсөн мөнгөн хандив, дэмжлэг
11. Иргэдэд өгсөн мөнгөн бус хандив, дэмжлэг
12. Гамшгаас хамгаалахад зориулсан зардал (Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу).

Аж ахуйн нэгж энэ тайлангаа гарган аудиторoor баталгаажуулан, дараахь тодорхойлолтыг хүлээн зөвшөөрсөн байна. Үүнд:

“Тус компаний энэхүү тайлан “Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурьт зарчмын дагуу боловсруулагдсан бөгөөд 20... оны санхүүгийн жилийн нэгдсэн тайлан “Нягтлан бодох бүртгэлийн тухай” Монгол Улсын 2001 оны хуулийн 10.1- д зааснаар Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу хийгдсэн. Тус компанийн санхүүгийн нэгдсэн тайланг баталгаажуулсан аудитын байгууллагын дүгнэлтийг хавсаргав.

Аж ахуйн нэгжийн зохих албан тушаалтны нэр, гарын үсэг, огноо зэргийг бичиж тамга дарна.

Монголын Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод

байдлын санаачлагын ажлын алба

Утас: (976)-70110525

Факс: (976)-70110155

- о о о -